СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2025/022/НА-СТА-ТШЗ**



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>www.open.audit.mn<br>Сүхбаатар сум<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br><br>Аудитор: Ж.Баясгалан<br>Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1.АУДИТЫН ДҮГНЭЛТ ... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ... 5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ... 11
4.АУДИТЫН ТАЙЛАН ... 15
4.1 Ерөнхий зүйл ... 15
4.2 Материаллаг байдал ... 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ... 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 16
4.5.1 Завсрын аудитын талаар ... 16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 17
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ... 17
5.1 Төлбөрийн акт ... 17
5.2 Албан шаардлага ... 18
5.2 Зөвлөмж ... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ... 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ХГБХХГ | Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, Хамгааллын газар |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| МУЕА | Монгол улсын Ерөнхий аудитор |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ГБХНХЯ | Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам |

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,366,917.00** | **79,094,613.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **51,366,917.00** | **79,094,613.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **8,061,710.00** | **2,897,210.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,061,710.00 | 2,897,210.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **43,305,207.00** | **76,197,403.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 129,800.00 | 789,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,888,271.00 | 66,030,003.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,674,000.00 | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 633,236.00 | |
| 35450 | Барилгын засварын материал | 2,978,000.00 | 2,978,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,001,900.00 | 6,399,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **683,040,269.73** | **680,795,854.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **683,040,269.73** | **680,795,854.89** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **633,538,269.73** | **631,293,854.89** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 596,803,135.60 | 596,803,135.60 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -68,098,391.10 | -86,257,962.06 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 23,500,000.00 | 23,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -11,260,416.82 | -14,197,916.86 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 113,699,624.28 | 160,426,524.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -60,957,246.04 | -83,200,655.48 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 61,840,458.00 | 61,840,458.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -30,019,760.31 | -34,801,635.75 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 18,684,631.00 | 18,684,631.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,728,764.88 | -11,637,723.84 |
| 39217 | Ном | 75,000.00 | 135,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **49,502,000.00** | **49,502,000.00** |
| 39301 | Программ хангамж | 563,340.00 | 563,340.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -563,340.00 | -563,340.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,502,000.00 | 49,502,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **734,407,186.73** | **759,890,467.89** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **334,309.79** |
| **413** | **Өглөг** | | **334,309.79** |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 311,534.79 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 22,775.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **734,407,186.73** | **759,556,158.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **734,407,186.73** | **759,556,158.10** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 200,497,379.82 | 200,497,379.82 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 200,497,379.82 | 200,497,379.82 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-45,530,057.80** | **-20,381,086.43** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -45,530,057.80 | -45,530,057.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 25,148,971.37 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 579,439,864.71 | 579,439,864.71 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **734,407,186.73** | **759,890,467.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,161,947,393.00** | **1,756,764,449.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,310,730.00** | **39,547,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **13,310,730.00** | **39,547,000.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 7,211,630.00 | 26,247,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6,099,100.00 | 13.300.000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,148,636,663.00** | **1,717,217,449.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,117,087,800.00** | **1,606,673,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,117,087,800.00 | 1,606,673,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **31,548,863.00** | **110,543,849.90** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 27,112,500.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 34,585,479.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,736,363.00 | 70,323,370.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 700,000.00 | 5,635,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,200,817,734.32** | **1,731,615,478.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,200,817,734.32** | **1,731,615,478.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,095,608,747.63** | **1,509,412,260.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **610,780,846.88** | **927,183,303.56** |
| 210101 | Үндсэн цалин | 417,152,573.77 | 546,356,890.61 |
| 210102 | Нэмэгдэл | 130,965,801.47 | 281,342,412.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,049,052.00 | 46,814,715.00 |
| 210104 | Урамшуулал | 36,613,419.64 | 52,669,285.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,634,386.54** | **116,783,834.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,227,715.51 | 80,781,570.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,123,420.13 | 10,368,577.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,592,934.89 | 4,664,186.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,039,889.58 | 4,164,203.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,650,426.43 | 16,805,296.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **60,023,890.89** | **112,218,851.94** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,053,044.81 | 7,175,722.58 |
| 210302 | Түлш, халаалт | 52,116,906.08 | 95,941,907.36 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,853,940.00 | 9,101,222.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,185,106.00** | **21,210,824.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,865,000.00 | 3,357,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,962,280.00 | 2,437,526.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,450,426.00 | 2,942,730.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 220,000.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,423,900.00 | 3,030,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,263,500.00 | 9,243,268.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **439,000.00** | **426,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 439,000.00 | 426,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,140,400.00** | **11,960,710.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 9,971,050.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,140,400.00 | 1,989,660.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **254,000.00** | **286,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 254,000.00 | 286,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **246,328,010.00** | **265,697,923.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 246,210,610.00 | 265,697,923.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 333,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 43,800.00 | 124,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 24,100.00 | 23,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 32,200.00 | 31,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 1,422,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 17,300.00 | 17,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **54,823,107.32** | **53,644,812.84** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,438,310.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,744,700.00 | 3,175,188.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 52,078,407.32 | 49,031,314.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **105,208,986.69** | **222,203,218.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,004,000.00** | **30,559,031.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 29,683,531.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,004,000.00 | 875,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **102,204,986.69** | **191,644,187.42** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,204,986.69 | 190,929,560.23 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 714,627.19 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-38,870,341.32** | **25,148,971.37** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-38,870,341.32** | **25,148,971.37** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,148,636,663.00** | **1,717,217,449.90** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,148,636,663.00** | **1,717,217,449.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,117,087,800.00** | **1,606,673,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,117,087,800.00 | 1,606,673,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **31,548,863.00** | **110,543,849.90** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 27,112,500.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 34,585,479.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,736,363.00 | 70,323,370.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 700,000.00 | 5,635,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,148,636,663.00** | **1,717,217,449.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,148,636,663.00** | **1,717,217,449.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,042,931,676.31** | **1,494,418,231.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **610,780,846.88** | **941,233,141.08** |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 416,602,573.77 | 560,686,590.61 |
| 210102 | Нэмэгдэл | 131,515,801.47 | 281,342,412.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,049,052.00 | 46,814,715.00 |
| 210104 | Урамшуулал | 36,613,419.64 | 52,389,422.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,634,386.54** | **116,752,162.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,097,054.66 | 81,061,432.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,410,285.35 | 10,057,042.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,822,427.09 | 4,664,186.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,095,735.33 | 4,164,203.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,208,884.11 | 16,805,296.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **60,023,890.89** | **112,218,851.94** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,053,044.81 | 7,175,722.58 |
| 210302 | Түлш, халаалт | 52,116,906.08 | 95,941,907.36 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,853,940.00 | 9,101,222.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,777,106.00** | **14,064,150.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,222,000.00 | 4,459,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,878,280.00 | 2,406,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,452,426.00 | 2,882,730.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,024,400.00 | 4,115,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **967,000.00** | **426,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 967,000.00 | 426,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,752,400.00** | **34,517,910.00** |
| 210601 | | | 30,510,950.00 |
| 210604 | Урсгал засвар | **38,752,400.00** | 4,006,960.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **254,000.00** | **286,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 254,000.00 | 286,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **243,007,046.00** | **250,138,718.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 242,889,646.00 | 248,225,618.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 333,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 43,800.00 | 101,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 24,100.00 | 23,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 32,200.00 | 31,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,422,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 17,300.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,735,000.00** | **24,781,298.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 21,122,310.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | **3,735,000.00** | 3,658,988.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **105,704,986.69** | **222,799,218.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,500,000.00** | **31,155,031.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 29,683,531.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,500,000.00 | 1,471,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **102,204,986.69** | **191,644,187.42** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,204,986.69 | 190,929,560.23 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 714,627.19 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **0.00** | **0.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **-45,530,057.8** | **734,407,186.73** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | 25,148,971.37 | 25,148,971.37 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **-20,381,086.43** | **759,556,158.10** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **-20,381,086.43** | **759,556,158.10** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **-20,381,086.43** | **759,556,158.10** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 25,148,971.37 | 25,148,971.37 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **200,497,379.82** | **579,439,864.71** | **-20,381,086.43** | **759,556,158.10** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,606,673,600.00** | **1,415,744,039.77** | **190,929,560.23** | **88.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,606,673,600.00** | **1,415,744,039.77** | **190,929,560.23** | **88.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,573,553,100.00** | **1,384,589,008.77** | **188,964,091.23** | **87.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **985,481,900.00** | **866,544,724.60** | **118,937,175.40** | **87.93** |
| 210101 | Үндсэн цалин | 578,311,200.00 | 533,362,149.93 | 44,949,050.07 | 92.23 |
| 210102 | Нэмэгдэл | 322,293,000.00 | 240,077,546.77 | 82,215,453.23 | 74.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,152,100.00 | 43,742,715.00 | -16,590,615.00 | 161.10 |
| 210104 | Урамшуулал | 57,725,600.00 | 49,362,312.90 | 8,363,287.10 | 85.51 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **123,185,100.00** | **107,469,716.23** | **15,715,383.77** | **87.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,766,000.00 | 74,749,369.31 | 9,016,630.69 | 89.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,854,800.00 | 9,314,447.12 | 540,352.88 | 94.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,927,300.00 | 4,292,888.97 | 634,411.03 | 87.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,927,400.00 | 3,792,905.85 | 1,134,494.15 | 76.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,709,600.00 | 15,320,104.98 | 4,389,495.02 | 77.73 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **165,094,300.00** | **112,218,851.94** | **52,875,448.06** | **67.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,420,100.00 | 7,175,722.58 | 13,244,377.42 | 35.14 |
| 210302 | Түлш, халаалт | 132,881,400.00 | 95,941,907.36 | 36,939,492.64 | 72.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,792,800.00 | 9,101,222.00 | 2,691,578.00 | 77.18 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,117,200.00** | **14,064,150.00** | **53,050.00** | **99.62** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,780,200.00 | 4,459,000.00 | 321,200.00 | 93.28 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,377,800.00 | 2,406,520.00 | -28,720.00 | 101.21 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,778,900.00 | 2,882,730.00 | -103,830.00 | 103.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 192,300.00 | 200,000.00 | -7,700.00 | 104.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,988,000 | 4,115,900.00 | -127,900.00 | 103.21 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,078,100.00** | **426,000.00** | **652,100.00** | **39.51** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,078,100.00 | 426,000.00 | 652,100.00 | 39.51 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **34,008,400.00** | **33,978,010.00** | **30,390.00** | **99.91** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,000,000.00 | 29,971,050.00 | 28,950.00 | 99.90 |
| 210604 | Урсгал засвар | 4,008,400.00 | 4,006,960.00 | 1,440.00 | 99.96 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **292,000.00** | **286,000.00** | **6,000.00** | **97.95** |
| 210702 | Дотоод албан томилолт | 292,000.00 | 286,000.00 | 6,000.00 | 97.95 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **246,628,800.00** | **245,942,568.00** | **686,232.00** | **99.72** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 244,029,500.00 | 244,029,468.00 | 32.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 799,700.00 | 333,600.00 | 466,100.00 | 41.72 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 101,900.00 | 101,900.00 | | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 104,000.00 | 23,600.00 | 80,400.00 | 22.69 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 90,500.00 | 31,600.00 | 58,900.00 | 34,92 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,422,400.00 | 1,422,400.00 | | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 80,800.00 | | 80,800.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,667,300.00** | **3,658,988.00** | **8,312.00** | **99.77** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,667,300.00 | 3,658,988.00 | 8,312.00 | 99.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,120,500.00** | **222,084,591.23** | **-188,964,091.23** | **670.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,120,500.00** | **31,155,031.00** | **1,965,469.00** | **94.07** |
| **213208** | **Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг** | **31,649,000.00** | **29,683,531.00** | **1,965,469.00** | **93.79** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,471,500.00 | 1,471,500.00 | | 100.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,606,673,600.00** | **1,415,744,039.77** | | **100.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,606,673,600.00** | **1,415,744,039.77** | | **100.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,606,673,600.00 | 1,415,744,039.77 | | 100.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2.00** | **2.00** | | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 2.00 | 2.00 | | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **43.00** | **35.00** | **8.00** | **81.40** |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 | | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31.00 | 24.00 | 7.00 | 77.42 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 9.00 | 1.00 | 90.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **43.00** | **35.00** | **8.00** | **81.40** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12.00 | 7.00 | 5.00 | 58.33 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 31.00 | 28.00 | 3.00 | 90.32 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **109,829,222.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **109,829,222.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **109,829,222.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **74,688,416.4** |
| 210101 | Үндсэн цалин | 27,324,440.6 |
| 210102 | Нэмэгдэл | 41,264,865.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,072,000.0 |
| 210104 | Урамшуулал | 3,027,110.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,282,446.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,312,063.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 742,595.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 371,297.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 371,297.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,485,191.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **539,900.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 539,900.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,196,150.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,196,150.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,122,310.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,122,310.0 |
| **1** | **Зардлын санхүүжүүлэх эх үүсвэр** | **109,829,222.7** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **109,829,222.7** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,585,479.4 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,308,743.5 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,934,999.7 |

# 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар */цаашид ХГБХХГ гэх/* нь "*Хөгжсөн хүүхэд хамгаалагдана*" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Хүүхдийн оролцоонд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэнэ.
- Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан хамгаалах үйлчилгээг хүргэнэ.

- Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын үйлчилгээг үйлчилгээг сайжруулж, хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

ХГБХХГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХГБХХГ-аас дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХГБХХГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурийаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХГБХХГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХГБХХГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,483.26 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 51,366.9 | 79,094.6 | 27,727.7 |
| Үндсэн хөрөнгө | 683,040.3 | 680,795.8 | (2,244.5) |
| **Нийт хөрөнгө** | **734,407.2** | **759,890.4** | **25,483.2** |
| Өр төлбөр | 0.0 | 334.3 | 334.3 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 734,407.2 | 759,556.1 | 25,148.9 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **734,407.2** | **759,890.4** | **25,483.2** |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл **79,094.6** мянган төгрөг болж өмнөх оноос 27,727.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд төсвийн хөрөнгөөр 180,695.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 401.9 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан, 13,300.0 мянган төгрөгийн материалыг хандиваар авсан болон 166,669.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл **680,795.8** мянган төгрөг болж өмнөх оноос 2,244.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилд 20,539.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 26,247.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар авсан болон 49,031.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.
- Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ажиллагсадтай холбоотой болон барааны үйлчилгээний төлбөр зэрэг нийт 334.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, тайлагнасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,488,279.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 80,337.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **1,568,617.50** мянган төгрөг болгон баталсан байна. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 150,709.1 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 18,838.5 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 21,324.7 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 28,660.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бол,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 88,227.6 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 13,927.2 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 121.9 мянган төгрөгөөр,
- Томилолт зочны зардлыг 2,208.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 23,977.00 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 10,732.7 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 2 удаа өөрчлөн, 38,056.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн */байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 68,980.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 15,331.3 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас 49,593.0 мянган төгрөгийг бууруулсан/* нийт **1,606,673.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,606,673.6** мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр **1,415,744.0** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулан, үлдэгдэл **190,929.6** мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,415,744.0 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн хөгжил, хамгаалал | 1,598,065.1 | 1,407,135.5 | (190,929.6) | 88.0 |
| 2 | Гэр бүлийн хөгжил, хамгаалал | 8,608.5 | 8,608.5 | 0.00 | 100.0 |
| | **Дүн** | **1,606,673.6** | **1,415,744.0** | **(190,929.6)** | **88.1** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130017401 тоот дансанд нийт **110,543.8** мянган төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэлээр **109,829.2** мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл **714.6** мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ХНХЯ-аас 3,080.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын захирамжаар 31,505.5 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-н захирамжаар 70,323.3 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 5,635.0 мянган төгрөг /*4,934.9 мянган төгрөгийг зарцуулсан*/ зэрэг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу ХГБХХГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ХГБХХГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,200,817.7 мянган төгрөгөөс **1** хувиар буюу 12,008.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, байгууллагын ойг тэмдэглэх зэрэгт төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,
- Зочин, төлөөлөгч хүлээн авах, үдэх, бэлэг дурсгалын зүйлсэд зардал гаргаагүй.
- Тогтмол зардлыг хэмнэсэн.
- Тус байгууллагад бүртгэлтэй 1 тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар буюу цэнхэр дугаарыг хэрэглэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ХГБХХГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 171 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар *"Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай"* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,017.6 | 1 | 1,017.6 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 3,566.7 | 1 | 3,566.7 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 6,221.9 | 1 | 6,221.9 | 100.0 |
| **Нийт дүн** | **3** | **10,806.2** | **3** | **10,806.2** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт **22,850.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,784.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 13,766.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

**1.** Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн зерэг арга” чиглүүлэгч багш бэлтгэх сургалтад хамрагдсан 2 ажилтанд 300.00 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү тооцож, олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалын 1 дэх ” *Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг ...Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 50.0 мянган төгрөгөөр, байрны зардлыг ...Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод 150.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн батлсугай” гэсэн заалтуудыг тус тус* зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Илүү олгосон албан томилолтыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

**1.** Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 19 ширхэг нийт **3,515.0** мянган төгрөгийн тусгай арга хэмжээний хувцас худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулан гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

**2**. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ажиллагсадтай холбоотой 311.5 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний зардлын 22.8 мянган төгрөгийн зэрэг нийт 334.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.** Төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлого болох 4,934.9 мянган төгрөгийг зарцуулах хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, зөвшөөрөл авалгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн " Журам батлах тухай" А/282 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь *"Энэ журмын 3.1.2-т заасан төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (орон нутгийн төсөвт байгууллагын хувьд орон нутгийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгж) хүлээн авч хянасны үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг хүргүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:***

*1.1* *Илрүүлэлт:* Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсаар илүү цагийг олгохдоо үндэслэл, агуулга, ажилласан огноо, гүйцэтгэсэн байршил, баталгаажуулалт зэргийг хөтлөлгүйгээр 13,766.1 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгож бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь *"Анхан шатны баримтын бүрдэлгүй*

*ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэсэн заалт болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 3.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*1.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>* Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтын дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн. | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 3,515.0 | | | 1 | 3,515.0 | | | | | | |
| Албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон | 1 | 300.0 | 1 | 300.0 | | | | | | | | |
| Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн | 1 | 334.3 | | | 1 | 334.3 | | | | | | |
| Нэмэлт орлогыг зөвшөөрөлгүйгээр зарцуулсан | 1 | 4,934.9 | | | 1 | 4,934.9 | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан | 1 | 13,766.1 | | | | | 1 | 13,766.1 | | | | |
| **Дүн** | **4** | **22,850.3** | **1** | **300.0** | **1** | **8,784.2** | **1** | **13,766.1** | | | | |